



The Asia Foundation

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Холбоо барих:

Эми Овэйл
415.743.3340
aovalle@asiafound.org

Дэбби Фэликс
415.743.3318
dfelix@asiafound.org

АНУ АЗИД АНХААРЛАХ ХАНДУУЛАХ ЦАГ БОЛЖЭЭ

Ази, Америкийн олон улс судлалын шилдэг мэргэжилтнүүд АНУ-ын Засгийн газрыг Азид анхаарал хандуулахыг зөвлөж байна

Хятадын өсөлтөд зориулж АНУ шат дараалсан алхмуудыг авах нь зүйтэй

ВАШИНГТОН, 2008 оны 9-р сарын 10 – Олон улс судлалын мэргэжилтнүүдийн бэлтгэн гаргасан “Америкийн нөлөө Азид: Ази, Америкийн үзэл баримтлал” тайлангийн нээлт өнөө өглөө Вашингтон хотод боллоо. Уг тайланд дурьдсанаар АНУ-ын эдийн засгийн нөхцөл байдал Азитай үндсэн зарчмуудаараа холбогдсон байгаа бөгөөд уг холбоо болон түүний шалтгаан, үр дүнг нарийн тооцоолон, ойлгож, тохирсон алхмуудыг яаралтай авах хэрэгтэй ажээ.

Хятадтай хамтрах харилцаа ерөнхийдөө үр дүн сайтай байгаа хэдий ч АНУ-ын аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтэд заналхийлж болохуйц нөлөөг багасгахын тулд шаардлагатай арга хэмжээнүүдийг ч мөн авсаар байх хэрэгтэй байгааг номонд бас дурьджээ. Азийн Сангийн дэмжлэгтэйгээр бэлтгэн гаргасан энэхүү тайланд Ази, АНУ-ын харилцаа, тэр дундаа Солонгос, Афганистан, Пакистан, Азийн бүсийн холбоод, худалдаа хөрөнгө оруулалтын талаар хийгдэж байсан өндөр, дээд хэмжээний болон хаалттай хуралдаануудын талаар тусгасан байна.

Дөрвөн жилд нэг удаа хэвлэгддэг энэхүү тайлан нь Азийн асуудалд хэрхэн анхаарал хандуулах, шийдвэрлэх арга замын талаар шаардлагатай зөвлөмжүүдийг АНУ-ын бодлого боловсруулагчдад санал болгодог билээ. Азийн асуудалд анхаарал хандуулахыг уриалан Ардчилсан нам болон Бүгд Найрамдах Намын хурлуудад зориулж тайлангийн дүгнэлтийг энэхүү хоёр намын олон улсын хэрэг эрхэлсэн зөвлөхүүдэд хүргүүлсэн билээ.

Тайлан Америк, Азийн үзэл баримтлал гэсэн хоёр хэсэгт хуваагдсан бөгөөд хэсэг тус бүрийг Ази, Америкийн харилцааны асуудлаар дэлхийд танигдсан мэргэжилтнүүд бэлтгэсэнээрээ онцлог юм. Америкийн үзэл баримтлалын хэсгийг төрийн нарийн бичгийн

дэд дарга асан, АНУ-аас Япон, Филиппин улсад элчин сайдаар сууж байсан, одоо Стенфордын Их Сургуулийн Ази, Номхон далайн төвийн хүндэт төлөөлөгчөөр ажиллаж байгаа Армакост болон төрийн нарийн бичгийн даргын туслах асан, АНУ-аас Индонези, Хятад, Сингапурт элчин сайдаар сууж байсан, Киссингэр Олон улсын хүрээлэнгийн дэд дарга Роё нар бэлтгэн гаргажээ. Харин Азийн үзэл баримтлалын хэсгийг Өмнөд Солонгосын Гадаад хэргийн сайд асан ноён Хан Сунг Жоу, Бодлого судлалын хүрээлэнгийн дарга Томми Ко болон Энэтхэгийн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гишүүн асан, Сингапурын Ражантан сургуулийн Олон улс судлалын профессор, НҮБ-ын Нью-Йорк дахь байнгын төлөөлөгч Доктор Ража Мохан нар бэлтгэн байна.

Конгрессийн гишүүнээр 26 жил ажиллах хугацаандаа Ази, Номхон далайн бүсийн дэд хороог тэргүүлж байсан Азийн Сангийн ерөнхийлөгч Даглас Бирайтер тайлангийн талаар хэлэхдээ “Энэхүү тайлан Америкийн ирээдүйн бодлого боловсруулагчдад Ази, Номхон далайн асуудлыг ойлгох, түүнийг хэрхэн шийдвэрлэхэд ихээхэн тус дөхөм болно гэж үзэж байна” гэжээ. Тэрээр мөн “Манай байгууллагын үндсэн зорилтуудын нэг бол АНУ, Азийн хоорондын түншлэлийг бэхжүүлэх явдал. Тиймээс Ази, Америкийн лидерүүд нэгдэж өндөр ач холбогдолтой тайланг хамтран гаргасан явдалд таатай байна” хэмээн нэмлээ.

Америкийн хэсгийн дүгнэлт, зөвлөмж:

- Шинэ засгийн газрын төлөвлөгөөнд худалдаатай холбоотой асуудлууд дээгүүр тавигдах ёстой. Тухайлбал, шуурхай хэлэлцээр хийх удирдлагыг дахин бүрдүүлэх, Дохагийн тойргийг дуусгах, АНУ – РОК чөлөөт худалдааны гэрээг батлах, Азийн худалдааны талаарх нэмэлт санаачлагуудыг гаргахдаа ОПЕК-ийн хэм хэмжээг тогтоох зэрэг орно. Эдгээрийг үл ойшоосноор АНУ-ын эдийн засгийн манлайллыг үгүй хийж болно.
- Дундад Ази болон Өмнөд Ази дахь терроризмтэй тэмцэх хандлагад стратегийн шинэ өөрчлөлт оруулснаар бусад гадаад бодлогийн асуудалд хэт их болон хэт бага нөлөө үзүүлэхгүй байх. Терроризмтэй тэмцэх Дэлхийн Дайн гэж нэрлэсэн нь харамсалтай алдаа байсан. Энэ нь цэргийн хүчинд чухал ач холбогдол өгөхийг уриалан дуудсан юм. Энэ нь зарим хүмүүст Исламчуудыг дайсан мэтээр ойлгуулсан. Үнэн хэрэгтээ удирдлагаа алдсан цөөн хэдэн Ислам бүлгээс болж үл итгэгчид нь жихад нар болон хувирсан юм. Бид боломжит Исламийн дайснуудыг нэг дор нь цуглуулах бус харин тэднийг хувааж, тэмцэх хэрэгтэй
- Эрчим хүчний асуудлаарх хамтын ажиллагаа. Дэлхийн бусад улс орны адил Азийн орнуудын тогтвортой өсөлт, хөгжилтөнд эрчим хүчний үнэ өндөр байгаа нь томоохон заналхийлэл болж байна. АНУ нь энэхүү өрсөлдөөний нэгээхэн хүчин зүйлийг агуулах зорилгоор эрчим хүчний аюулгүй байдлыг хөхиүлэн дэмжсэн хамтын ажиллагааг бий болгох бодлогуудыг дэмжих замаар өөрсдийн хувь нэмрээ оруулж чадна. Ихэнх Азийн орнууд импортын шатахуун хэрэглэдэг. АНУ-тай харилцах хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр ОПЕК болон бусад үйлдвэрлэгчдийг газрын тос болон байгалийн хийн олборлолтоо ихэсгэхийг хамтран ятгаснаар бүгд үр шимийг нь хүртэх болно. Ингэснээр байгаль орчинд сөрөг нөлөөгүй шатахууны нээлтийг түргэсгэх, одоогийн байгаа нөөцөө илүү үр дүнтэй ашиглах, гэнэтийн хэрэгцээнд зориулж нөөц бий болгох зэрэг үр шимийг хүртэж болох юм

Азийн хэсгийн дүгнэлт, зөвлөмж:

- АНУ нь өөрсдөд буй үнэт зүйлсээ хамгаалах тал дээр сайн жишээ үзүүлэхэд зөвлөх. АНУ-ын нэг бүс нутаг дахь холбоотнууд нь АНУ-ын сул дорой төрх, дараагийн засгийн газрын гадаад бодлого нь олон нийтрүүгээ чиглэсэн байгаасай гэсэн өөрсдийнх нь хүслийг мэддэг. Улс төрийн, оюун ухааны болон соёлын харилцааны гүүр батжих тусам АНУ, Ази аль алинд нь ашиг тусаа үзүүлэх юм.
- АНУ нь Азийн бүсийн архитектурт идэвхитэй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хоёр талт хамтын ажиллагаа чухал хэдий ч улс дамжсан дипломат харилцаа, тэр дундаа улс төр, эдийн засаг, болон аюулгүй байдлын талаарх асуудалд илүү анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд, Олон Улсын Нөхөрлөл, Хамтын Ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурах. Ингэснээр АНУ-ыг Зүүн Азийн Дээд хэмжээний уулзалтын гишүүдтэй идэвхитэй харилцах, гол түнш байх нөхцөл бололцоог олгоно.
- Шинэ удирдлагууд Азийн бүсийн байгууллагуудтай эрчим хүчний аюулгүй байдал болон цаг агаарын өөрчлөлтийн талаарх харилцааг эхлүүлэх хэрэгтэй – тэр дотроо ногоон хүлэмжийн хийн ялгаруулалтыг зогсоох, мөн Киотогийн хэлэлцээрийг амжилттай хэрэгжүүлэх. АНУ нь өөрсдийн эрчим хүчний зохистой хэрэглээ, тэр дундаа дахин сэргээгдэх эрчим хүч, мөн нүүрстөрөгчийн хадгалалт, хураалт зэргийн талаарх туршлагаасаа хуваалцах хэрэгтэй.

Тайлангийн эх хувь, танилцуулга болон дүгнэлтийг Та www.asiafoundation.org вебсайтаас татаж авч болно.

Азийн Сангийн талаар

Азийн сан нь ашгийн бус, төрийн бус байгууллага бөгөөд Ази Номхон далайн бүсийн энх тайван, хөгжил цэцэглэл, шударга ёс, нээлттэй нийгмийн хөгжилийн төлөө ажилладаг. Азийн сан нь нутгийн удирдлага, эрх зүй, иргэний нийгэм, эмэгтэйчүүдийн бүрэн эрх, эдийн засгийн өөрчлөлт бө дэвшил, болон олон улсын харилцаанд тус дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг. Азид үйл ажиллагаагаа явуулсан 50 жилийн туршлагадаа үндэслэн Азийн сан нь хувийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран манлайлал, байгууллагын хөгжил, харилцан солилцох болон бодлогын судалгаа зэрэгт дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Азийн сан нь Сан Францискод төвтэй, Азийн 17 орон болон Вашингтон хотод салбартай бөгөөд дээр дурьдсан асуудлуудыг улсын болон бүсийн хэмжээнд авч үздэг. 2007 онд 68 сая ам.долларын тусламжийг хөтөлбөрт, 33 сая ам.долларын өртөг бүхий 974,000 ном, сурах бичгийг Азийн орнуудад хандивласан

Азийн сан нь хандивийн байгууллага бус бөгөөд өөрсдийн зорилгодоо хүрэх эрмэлзэл бүхий донор байгууллагуудын мөнгөн тусламжнаас хамааралтай байдаг. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.asiafoundation.org вебсайтнаас үзнэ үү.